



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 221

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ойн судалгаа, хөгжлийн төвийн албан ажлын хэрэгцээнд зориулан 648,474,000.00 (зургаан зуун дөчин найман сая дөрвөн зуун далан дөрвөн мянган) төгрөгт багтаан 7 ширхэг автомашин худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины техникийн үзүүлэлтийг хавсралтаар тогтоосугай.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, Ойн судалгаа, хөгжлийн төвийн захирал Д.Мөнхбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001910

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн
..... дугаар тогтоолын хавсралт



ОЙН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ХУДАЛДАН АВАХ
АВТОМАШИНЫ ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Д/д	Автомашинь техникийн үзүүлэлт	Суудлын тоо	Тоо ширхэг	Хөрөнгө худалдаж авах үнийн дээд хязгаар (төгрөг)	
				Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Том оврын трактор, ТҮМ-Т1003, 100 морины хүч буюу 74.5 кВт 4400 см3	1	1	160 094 000,0	160 094 000,0
2	Дунд оврын трактор, ТҮМ-Т503, 50.7 морины хүч буюу 37.3 кВт 2200 см3	1	2	79 690 000,0	159 380 000,0
3	Зил-131, 150 морины хүч буюу 111.9 кВт /мод цагаалгын машин/	3	2	29 268 000,0	58 536 000,0
4	Норд бенц, 380 морины хүч буюу 283.6 кВт /тууш тээврийн машин/	3	1	160 464 000,0	160 464 000,0
5	Ландкрузер-200, 4500 cc /хууль бус ой ашиглалттай тэмцэх тасагт шаардлагатай туулах чадвар сайтай/	5	1	110 000 000,0	110 000 000,0
Нийт дүн		-	7	539,516,000.00 (таван зуун гучин есөн сая таван зуун арван зургаан мянган)	648,474,000.00 (зургаан зуун дөчин найман сая дөрвөн зуун далан дөрвөн мянган)